Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.01.06 Өмнөговь аймаг

НЭГ. Товч танилцуулга
Өмнөговь аймгийн хэмжээнд 156 төрийн байгууллагаас 129 төрийн байгууллага Ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байна. 15 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба 2-4 хүний бүрэлдэхүүнтэй тул ёс зүйн дэд хороо байгуулаагүй болно. Мөн Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар, Өмнөговь аймаг дахь Прокурорын газар, Ханбогд сум дахь прокурорын газар, Шүүхийн Тамгын газар зэрэг байгууллагуудын ёс зүйн дэд хороог дээд шатны байгууллагууд нь байгуулан ажиллаж байна. Улсын төсөвт үйлдвэрийн 5 газар (Буянт хотхон УТҮГ, Хот тохижилт, Төрийн үйлчилгээний алба, Цогт-Овоо, Сэврэй сумдын сум дундын ойн ангиуд тус тус ёс зүйн дэд хороо байгуулаагүй болно. Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороог Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авсан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/514 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Ёс зүйн дэд хорооны даргаар Ч.Энхмөнх (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга), гишүүдэд Б.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн дарга), Г.Уугантуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн), Д.Наранчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн), Нарийн бичгийн даргаар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Орон нутгийн бодлого тогтоол, шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхсайхан нар ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллагуудын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах, төсвийн сахилга хариуцлагыг чангатгаж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтэн 32 хүн, агентлаг, төсвийн байгууллагуудын дарга нар, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нарийн бичгийн дарга, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Санхүүгийн албаны дарга, сумдын Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга, Соёлын төвийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан

тушаалтнууд, аймаг, сумын төрийн болон төсөвт байгууллагын нягтлан бодогчид, сум, агентлаг, төсөвт байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд зэрэг нийт 850 гаруй төрийн албан хаагч хамрагдсан. Ёс зүй, сахилга хариуцлагын зөвлөгөөний үеэр "Ёс зүйтэй төрийн алба", "Төрийн албаны шинэтгэл-Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт", "Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, анхаарах асуудлууд" сэдвүүдээр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Гавьяат хуульч Б.Идэрчулуун *болон ТАЗ-ийн Маргаан хянан шалгах газрын дарга* Ч.Бат-Эрдэнэ, Референт Р.Жавзандулам нар сургалт, мэдээллийг өгч, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Ёс зүйн дэд хороодын ажиллах журам, Ёс зүйн хорооноос баталсан бусад тогтоол, шийдвэрүүдийн талаар Монгол Улсын Ёс зүйн хорооны Ажлын албаны Гомдол мэдээлэл хариуцсан референт Д.Мөнхбат мэдээллийг өгч ажиллав. Мөн Өмнөговь аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн төрийн албан хаагчдын ангилал, төрлийг сүүлийн 4 жилээр гарган танилцуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд цаашид анхаарах асуудлын талаар мэдээллийг өгч ажилласан.

Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг чанаржуулах зорилготой "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" говийн бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд Өмнөговь аймагт *зохион байгуулж Өмнөговь аймгаас* 419, Дундговь аймгаас 125, Дорноговь аймгаас 119, Говьсүмбэр аймгаас 125 нийт 780 гаруй төрийн албан хаагчид оролцлоо. Тус зөвлөгөөний эхний өдрүүдэд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэглээ, хэрэгжилт сэдвүүдээр салбар хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Салбар хэлэлцүүлгүүдэс "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт" салбар хэлэлцүүлэгт удирдах болон гүйцэтгэх албан тушаалын нийт 100 төрийн албан хаагч оролцсон хамгийн үр дүнтэй хэлэлцүүлэг болсон.

Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, АУ-ны доктор, дэд профессор М.Цэрэнбат багшийг урьж ирүүлэн 2025 оны 09 дүгээр сарын 04-ний эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн талаарх сургалтыг Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл 120 гаруй эмч, эмнэлгийн ажилчдад, аймгийн Цагдаагийн газрын 50 гаруй албан хаагчдад, 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлаг, төсөвт байгууллагуудын 150 гаруй төрийн албан хаагчдад тус тус сургалтыг зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь Салбар зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар болон Төрийн албаны тухай хуулиар 16 байгууллагад биечлэн очиж нийт 436 төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулж, ёс зүйн дэд хороодын бүрэлдэхүүнд заавар чиглэл өгч ажилласан.

2025 оны 10 дугаар сарын 9-12-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн "Зүүн бүс"-ийн 8 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд уулзалт, зөвлөгөөнийг Цогт-Овоо суманд зохион байгуулж төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ёс зүйн төлөвшлийг дээшлүүлэх зорилгоор "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд" сэдвээр Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, АУ-ны доктор, дэд профессор М.Цэрэнбат багш, "Амьдралын үнэ цэнэ" сэдвээр Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн лектор Г.Бандицэрэн нар сургалт хийлээ. Энэхүү сургалтад 190 төрийн албан хаагч хамрагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын дагуу жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг "Соёл, урлагийн ажилтны өдөр"-ийн 32 дахь удаагийн арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Номгон суманд зохион байгуулагдаж соёл, урлагийн салбарын 17 байгууллагын 160 гаруй албан

хаагчдад ёс зүй, харьцаа хандлагын сэдвээр доктор (Ph.D), дэд профессор М.Цэрэнбат, лектор Г.Бандицэрэн (Чила), сургалтын менежер Э.Амартүвшин нар илтгэл, сургалтыг зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлөөс тогтмол зохион байгууллагддаг 7:4:10 "Цахим мэдээллийн цагийн хөтөлбөр" сургалтын хүрээнд төрийн байгууллага бүр албан хаагчдыгаа тогтмол хамруулаж, энэхүү ажил хэвшил болсон.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 15 дугаар тушаалаар "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяны хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх дараах сургалт арга хэмжээг байгууллага бүр байгууллагын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийг сурталчлан таниулах, "Авилгаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх" чиглэлээр "Авилгын тухай ойлголт хор хөнөөл", "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Авилгын гэмт хэрэг" зэрэг сэдвүүдээр мэдлэг сорих АХА тэмцээн зохион байгуулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн.

"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилт 1.1.1, 1.1.2, 1.1.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Ёс зүйн дэд хорооноос байгууллагын болон 15 сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох, үнэлэх ажлыг "Тогтвортой хөгжилд таны тэмүүлэл" НҮТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Үнэлгээнд Засаг даргын Тамгын газрын Удирдлагын багийн 9 гишүүний 5 буюу 55 хувь, 7 ахлах мэргэжилтэн 100 хувь, нийт албан хаагчдын 75 хувь, Сумын Засаг даргын Тамгын газар, Засаг дарга, Засаг даргын орлогч, багийн Засаг дарга болон суманд ажиллаж буй агентлагуудын төлөөлөл нийт 446 төрийн алба хаагчдыг үнэлгээнд хамруулахаас 249 буюу 55.8 хувь нь хамрагдсан байна. Эрсдэлийн түвшинг агуулгаар, албан тушаалаар нь эрэмбэлэн дүгнэлт, зөвлөмжийг гарган ирүүлсэн байна.

Уг дүгнэлт, зөвлөмжийг нарийвчлан судалж, Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөөд байна.

Салбар зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдон гарсан эрх зүйн баримт бичгүүдээр "Төрийн албан хаагчийн ёс зүйн гарын авлага"-ыг 1000 ш хэвлүүлэн төрийн байгууллага, албан хаагчдад тараан сурталчилсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

- Засаг даргын Тамгын газрын дарга нь Ёс зүйн дэд хорооны гишүүд болон байгууллагын удирдлага, албан хаагчдыг сургалтад хамруулах, Төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг бүс нутгийн болон аймаг орон нутаг, байгууллагын хэмжээнд тогтмол зохион байгуулан ажилласан.
- Дэд хорооны үйл ажиллагаа, бие даасан, хараат бус зарчмаар ажиллахад дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжоор ханган, гишүүдийн урамшуулал, чадавхжуулахтай холбогдох зардал, эрсдэлийн үнэлгээний зардлыг шийдвэрлэн, санхүүжүүлж ажилласан. Энэ хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар гишүүдийн урамшуулалд 3.960.000 төгрөг, Эрсдэлийн үнэлгээний зардалд 7.000.000 төгрөг, нийт 10.960.000 төгрөгийг зарцуулсан байна.
- Сум, байгууллага бүр шинээр томилогдсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г танилцуулан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах, ажлын орчинд харилцан хүндэтгэлтэй, шударга, хариуцлагатай хандлагыг төлөвшүүлэхэд анхааран ажиллаж байна.
- Ёс зүйн хорооны мэдээллийн самбарын мэдээ, мэдээллийг шинэчлэх: Байгууллагын ёс зүйн хорооны самбарыг шинэчлэн улирал бүр шинэчлэн иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад нээлттэй мэдээллээр ханган ажиллаж байна. Тухайлбал самбарт ёс зүйн хорооны гишүүдийн танилцуулаг, мөн ёс зүйн зөрчил

мэдээлэл хүлээн авах талаарх мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг нээлттэй мэдээллэн ажиллаж байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа: Ёс зүйн дэд хороодууд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Үүнд: • "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилт 1.1.1, 1.1.2, 1.1.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Ёс зүйн дэд хорооноос байгууллагын болон 15 сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох, үнэлэх ажлыг "Тогтвортой хөгжилд таны тэмүүлэл" НҮТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Уг ажилд 7.000.000 төгрөгийг зарцуулсан. • Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсэгт заасны дагуу Тамгын газрын даргын 2025 оны А/552 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан урамшуулал олгох шийдвэр гаргаж, нийт 3.960.000 төгрөгийн урамшууллыг олгосон байна. • Ёс зүйн дэд хороонд албан хаагчтай холбоотой 1 гомдол ирснийг хүлээн авч, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.1-д заасны дагуу гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгаж, нотлох баримт, холбогдох шийдвэрийг Захиргааны Ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу хувийн хэрэг бүрдүүлэн, дүгнэлт гарган, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. "Дүгнэлт"-ийг дэд хорооны Нарийн бичгийн дарга Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу талуудад мэдэгдэж, "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо цахим системд бүртгэсэн. • "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд дэд хорооны бүрэлдэхүүн, 2025 оны төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, ирсэн гомдол мэдээлэл түүнийг шийдвэрлэсэн шийдвэрийг бүртгэх, тайлагнах ажлыг хугацаанд нь гүйцэтгэн ажилласан байна. • Аймгийн Засаг даргын Тамгын газраасТөрийн албаны зөвлөлд байгууллагын удирдлагын зүгээс албан хаагчдыг сургалтад хамруулах хүсэлт тавьснаар 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооны ажлын албанаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар Монгол Улсын Төрөөс баримтлах бодлого, олон улсын туршлага, төрийн албаны ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудлууд, байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ, гомдол мэдээллийн шийдвэрлэлт, ТАХ-ын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний аргачлал, ТАХ-ын хүний нөөц, чадамжийн хүрээ түүний эрх зүйн зохицуулалт зэрэг чиглэлээр танхимын сургалтад нийт 46 албан хаагч буюу албан хаагчдын 83.6 хувь нь хамрагдсан. Сургалтад хамрагдсанаар албан үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ёс зүйн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн. • Аймгийн Засаг даргын Тамгын газар 2 гомдлыг хүлээн авч хэлэлцэн ёс зүйн зөрчилтэй гэсэн дүгнэлтийг гарган томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажилласан бөгөөд Ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т зааснаар байгууллага албан хаагчдын өмнө нээлттэй сануулах ёс зүйн хариуцлагыг

ногдуулсан байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ёс зүйн дэд хороо 1 гомдлыг хүлээн авч хэлэлцэн ёс зүйн зөрчилгүй байсан тул 2 хүнийг эвлэрүүлэн ажилласан байна.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
-Ёс зүйн дэд хорооноос байгууллагын болон 15 сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох, үнэлэх ажлыг "Тогтвортой хөгжилд таны тэмүүлэл" НҮТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлснээр ирүүлсэн тайлан, дүгнэлт, зөвлөмжийн дагуу Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн Иргэдтэй харилцах ур чадвар, үйлчилгээний чанарыг сайжруулах, албаны мэдээлэл ашиглах, хамгаалах хяналтыг сайжруулах зэрэг ажил, арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажиллах боломжтой болсон. Эдгээр сайжруулалтын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлснээр байгууллагын ёс зүйн соёл бэхжиж, төрийн үйлчилгээний чанар сайжирч, улмаар иргэдийн итгэл нэмэгдэх нөхцөл бүрдэх үр дүнтэй. -Шинээр томилогдсон албан хаагчдад анхан шатны чиглүүлэх сургалт орж хэвшсэн. -Албан хаагчид болон иргэд Ёс зүйн дэд хороонд хандаж гомдлоо шийдүүлэх, зөвлөгөө мэдээлэл авах нь ихэссэн. -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг таниулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг хийсний үр дүнд албан хаагчид ёс зүйн зөрчил гаргалгүй, төрийн албан хаагчид ёс зүйн тухай ойлголтыг авч мөрдөж ажиллаж байна. -Албан хаагчдын оролцоо нэмэгдсэн. -"Ёс зүйн дэд хорооны гишүүд байнгын мэдээлэл, судалгаа хийх чадвар дээшилсэн.	-Эрсдэлийн үнэлгээг анх удаа өгч байгаа болон эрсдэлийн үнэлгээнд эрсдэлийн агуулгын утгыг бүрэн ойлгоогүй, тоон өгөгдөл өгөхдөө үнэлгээний аргачлалд заагаагүй өөр тоон (0 эсвэл хоосон орхих) утга бичиж тэмдэглэсэн байсан зэрэг нь үнэлгээг бодитой үнэлж ирүүлсэн эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байлаа. -Шалгагдсан албан хаагчдаас сөрөг сэтгэгдэл ирүүлдэг. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн цалин урамшууллыг олгох, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хязгаарлуулдаг, санхүүгийн дотоод аудитын шалгалт ирэх үед урамшуулал олгосон тохиолдолд акт тавьдаг учраас гишүүд урамшууллаа авах хугацаандаа авч чадахгүй байна. -Ёс зүйн дэд хороонд ажиллах сонирхолтой албан хаагч хомс болж байна. -Ямар нэгэн үйл ажиллагаа сургалт сурталчилгаа явуулахад санхүүгийн хэрэгцээ шаардлага үүсэж байна.
Санал:	
- Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг чадавхжуулах, сургалтад хамруулах, мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах. - Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүд нь үндсэн ажлынхаа хажуугаар ёс зүйн дэд хороодын чиг үүргийг хариуцан, нэмэлт ачаалалтайгаар ажиллаж байгаа тул тэдний гүйцэтгэл, оролцоог бодитоор үнэлж, урамшууллын асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна. - Ёс зүйн дэд хорооны тайланг хагас, бүтэн жилээр татан хянаж үнэлгээ тавин, зөвлөмжийн хамт салбар ёс зүйн дэд хороодод хүргүүлж байх. - Батлагдсан орон тоотой болох.	

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

ТАНИЛЦСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.АМАРТӨГС

ХЯНАСАН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
/Хууль, эрхзүйн хэлтсийн дарга/ Ч.ЭНХМӨНХ

ТАЙЛАН БИЧСЭН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
/Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
ахлах мэргэжилтэн/ Ч.МӨНХСАЙХАН

2026 оны 01 дүгээр сарын 06

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 0 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ" НЭГТГЭЛ

2026.01.06 **ӨМНӨГОВЬ АЙМАГ**

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	0.96	9.57
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0.92	9.21
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.49	4.90
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.47	4.67
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.41	4.07
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.44	4.36
Хэсгийн оноо				**4**	**3.68**	36.78
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0.93	9.27
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0.67	6.74
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.34	3.38
Хэсгийн оноо				**3**	**1.94**	19.39
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	0.85	8.50
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0.93	9.32
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0.68	6.80
Хэсгийн оноо				**3**	**2.46**	**24.62**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.08**	**80.79**

ТАНИЛЦСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.АМАРТӨГС

НЭГТГЭСЭН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАЯРНАСАН

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ" -ӨМНӨГОВЬ АЙМАГ

2025.01.06

				АЗДТГ		Байгаль орчны газар		Биеийн тамир спортын газар		ГХБХБГ		Хүнс хөдөө аж ахуйн газар		Худалдан авах ажиллагааны газар		Эрүүл мэндийн газар		Орон нутгийн өмчийн газар		Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар		УЦУОШТ		Бүсийн оношилгоо эмчилгээний төв		Нийт	
№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3	4	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (YXX)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]	1	1	10	1	10	1	10	0.5	5	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.95	9.55
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]	1	1	10	1	10	0	0	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.91	9.09
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаат хэрэгжүүлсэн байдал — Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.50	5.00
		Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0	0	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.45	4.55
		Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан [illegible][8]	0.5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.50	5.00
		Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0.5	0.5	5	0.5	5	0	0	0.4	4	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.45	4.45
Хэсгийн оноо			**4**	**4**	**40**	**4**	**40**	**2.5**	**25**	**3.4**	**34**	**3.5**	**35**	**4**	**40**	**4**	**40**	**4**	**40**	**4**	**40**	**4**	**40**	**4**	**40**	**3.76**	**37.64**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*өмнөх дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо*)	1	0.5	5	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.95	9.55
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]	1	1	10	0	0	1	10	0.5	5	1	10	1	10	1	10	0.5	5	1	10	1	10	0	0	0.73	7.27
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]	1	1	10	0	0	0	0	0.5	5	0	0	0	0	1	10	0	0	0	0	1	10	1	10	0.41	4.09
Хэсгийн оноо			**3**	**2.5**	**25**	**1**	**10**	**2**	**20**	**2**	**20**	**2**	**20**	**2**	**20**	**3**	**30**	**1.5**	**15**	**2**	**20**	**3**	**30**	**2**	**20**	2.09	20.91
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]	1	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1.00	10.00
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (*Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно*)	1	0.5	5	0.5	5	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.5	5	0.86	8.64
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	1	10	0	0	1	10	0.5	5	1	10	1	10	1	10	1	10	0	0	1	10	0.5	5	0.73	7.27
Хэсгийн оноо			**3**	**2.5**	**25**	**1.5**	**15**	**3**	**30**	**2.5**	**25**	**3**	**30**	**3**	**30**	**3**	**30**	**3**	**30**	**2**	**20**	**3**	**30**	**2**	**20**	**2.59**	**25.91**
Үнэлгээний нийт оноо, хувь			**10**	**9**	**90**	**6.5**	**65**	**7.5**	**75**	**7.9**	**79**	**8.5**	**85**	**9**	**90**	**10**	**100**	**8.5**	**85**	**8**	**80**	**10**	**100**	**8**	**80**	**8.4**	**84.5**

ТАНИЛЦСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.АМАРТӨГС

НЭГТГЭСЭН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАЯРНАСАН

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

2026.01.06

Өмнөговь аймгийн сумдын ЗДТГ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Даланзадгад сум		Баян-Овоо сум		Баяндалай сум		Булган сум		Гурвантэс сум		Мандал-Овоо сум		Манлай сум		Ноён сум		Номгон сум		Сэврэй сум		Ханбогд сум		Ханхонгор сум		Хүрмэн сум		Цогт-Овоо сум		Цогт-Цэцэй сум		Нийт	
					Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6	5	6		
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлах, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.8	8	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.6	6	1	10	1	10	1	10	0.96	9.6
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	0	0	0.93	9.33
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0.5	5	0.2	2	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.48	4.8
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0.5	5	0.2	2	0.5	5	0	0	0	0	0.5	5	0	0	0.5	5	0.5	5	0	0	0	0	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.31	3.13
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн мэдээ бөглөсөн байдал[9]	0.5	0.5	5	0.2	2	0.5	5	0	0	0.5	5	0.4	4	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.5	5	0.3	3	0.5	5	0.5	5	0.5	5	0.43	4.27
		Хэсгийн оноо		4	4	40	2.8	28	4	40	3	30	3.5	35	3.7	37	3.5	35	4	40	4	40	3.5	35	3.5	35	3.4	34	4	40	4	40	3	30	3.593333	35.933333
4		Ёс зүйн дад хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хүчийн жилээр тооцох бөгөөд гомдол цэцэлсэн бол 1 оноо)*		1	1	10	1	10	0.5	5	0	0	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	0.9	9
5	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал (ЁЗМ)	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0	0	0	0	1	10	0.8	8	1	10	1	10	0	0	1	10	0.5	5	1	10	1	10	1	10	0	0	1	10	0	0	0.62	6.2
6		Ёс зүйн дад хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санкүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0	0	0	0	1	10	0	0	0	0	0	0	0	0	0.5	5	0	0	1	10	0.5	5	0	0	1	10	0	0	0	0	0.27	2.67
		Хэсгийн оноо		3	1	10	1	10	2.5	25	0.8	8	2	20	2	20	1	10	2.5	25	1.5	15	3	30	2.5	25	2	20	2	20	2	20	1	10	1.79	17.87
7	Ёс зүйн дад хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дад хорооны бүрэлдэхүүн хэвлэгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10	1	10	1	10	0.5	5	0	0	1	10	0	0	1	10	1	10	1	10	1	10	1	10	0	0	1	10	0	0	0.7	7
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хүчийн жилээр тооцно)*		1	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дад систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0	0	1	10	1	10	1	10	0.5	5	1	10	0.5	5	1	10	0.5	5	1	10	1	10	1	10	0	0	0	0	0	0	0.633333	6.3333333
		Хэсгийн оноо		3	2	20	3	30	3	30	2.5	25	1.5	15	3	30	1.5	15	3	30	2.5	25	3	30	3	30	3	30	1	10	2	20	1	10	2.33	23.33
		Үнэлгээний нийт оноо, хувь		10	7	70	6.8	68	9.5	95	6.3	63	7	70	8.7	87	6	60	9.5	95	8	80	9.5	95	9	90	8.4	84	7	70	8	80	5	50	7.71	77.13

ТАНИЛЦСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.АМАРТӨГС

НЭГТГЭСЭН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАЯРНАСАН

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ч.ЭНХМӨНХ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 24

Даланзадгад сум

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Ёс зүйн хорооноос зохион байгуулсан сургалтад хамрагдах, арга зүйн зөвлөгөө авах	Хамрагдсан сургалтын тоо	1	I-IV улирал	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
2	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	1	I-IV улирал	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	40		
3	Шинээр ажилд орсон албан хаагчид чиглүүлэх 8 цагийн сургалт зохион байгуулах	Шинээр ажилд орсон албан хаагчийн хамрагдалтын хувь	100	I-IV улирал	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
4	Дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, нотлох баримт, холбогдох бусад баримтыг цахим мэдээллийн санд бүртгэнэ.	Ирсэн гомдол, мэдээллийг цахим санд бүртгэсэн хувь	100	I-IV улирал	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
5	Байгууллагад гарч байгаа болон, үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх	Дүн шинжилгээ хийсэн ажлын гүйцэтгэлийн хувь	100	I-IV улирал	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
6	Дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгаж, шийдвэрлэнэ.	Ирсэн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь	100	I-IV улирал	Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд
7	Дэд хорооны дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	Ирсэн гомдол мэдээлэлд үндэслэн гаргасан шийдвэрийн шийдвэрлэлтийн хувь	100	I-IV улирал	Нарийн бичгийн дарга

8	Дэд хорооны ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх	Хугацаанд нь хүргүүлсэн тайлан мэдээллийн тоо	1	I-IV улирал	Нарийн бичгийн дарга
9	Холбогдох материалыг архивын нэгж үүсгэн, архивын асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгөх	Хүлээлгэн өгсөн архивын нэгжийн тоо	1	2026 оны I улирал	Нарийн бичгийн дарга

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ: О.Оргилболд О.ОРГИЛБОЛД